## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Аудитын код: ХОА**-2021/102/**СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Ховд хот<br>2021 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: Ц.Аззаяа<br>Утас: 70432545<br>цахим хаяг: AzzayaTs@audit.gov.mn |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| *АДБОУС* | *Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт* |
| *АОУС* | *Аудитын Олон Улсын Стандарт* |
| *УСНББОУС* | *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* |
| *ТТЗ* | *Төсвийн төвлөрүүлэн захирагч* |
| *ТШЗ* | *Төсвийн шууд захирагч* |
| ЕПГ | *Ерөнхий прокурорын газар* |
| *НДШ* | *Нийгмийн даатгалын шимтгэл* |
| *ХАОАТ* | *Хүн амын орлогын албан татвар* |
| *ТС* | *Төрийн сан* |

## Агуулга


1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт ....3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....Error! Bookmark not defined.

3. Аудитын тайлан ....9

3.1. Ерөнхий зүйл ....9

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....10

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....10

3.4. Материаллаг байдал ....10

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....10

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....12

3.7. Шилэн дансны мэдээлэл....12

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....12

3.9. Аудитын илрүүлэлт....13

Залруулсан алдаа ....13

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил...Error! Bookmark not defined.

Аудитын зөвлөмж ....13

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....13

4. Менежментийн захидал ....13

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....13

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.01.28 № 2/08

танай ____________-ны №____________-т

БУЛГАН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ХУУЛЬ ЦААЗЫН ИТГЭМЖИТ ЗӨВЛӨХ Б.БАТБАЯР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сум дахь сум дундын прокурорын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Булган сум дахь сум дундын прокурорын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган сум дахь сум дундын прокурорын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,198,700.0** | **11,891,900.0** |
| **33** | **АВЛАГА** | 79,000.0 | 00.0 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 79,000.0 | 00.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8,119,700.0 | 11,891,900.0 |
| **354** | **Хангамжийн материал** | 8,119,700.0 | 11,891,900.0 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,782,800.0 | 2,390,000.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 969,400.0 | 1,489,400.0 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.0 | 1,320,000.0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,250,000.0 | 5,075,000.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 117,500.0 | 1,617,500.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **332,433,982.0** | **372,828,874.6** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 332,433,982.0 | 372,828,874.6 |
| **392** | **Биет хөрөнгө** | 326,871,982.0 | 367,266,874.6 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 287,057,750.0 | 314,879,750.0 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -6,242,493.4 | -12,484,986.7 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 20,000,000.0 | 20,000,000.0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.0 | -6,666,666.7 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 28,732,258.7 | 53,464,336.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -19,114,963.9 | -17,199,939.3 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,588,400.0 | 31,544,080.4 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,148,969.4 | -16,269,699.1 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,562,000.0 | 5,562,000.0 |
| 39301 | Програм хангамж | 715,000.0 | 715,000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -715,000.0 | -715,000.0 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,562,000.0 | 5,562,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **340,632,682.0** | **384,720,774.6** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **340,632,682.0** | **384,720,774.6** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 340,632,682.0 | 384,720,774.6 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 45,809,850.8 | 45,809,850.8 |
| 51101 | Өмч: - төрийн | 45,809,850.8 | 45,809,850.8 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 290,183,125.9 | 334,271,218.4 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 290,183,125.9 | 290,183,125.9 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.0 | 44,088,092.5 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,639,705.4 | 4,639,705.4 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **340,632,682.0** | **384,720,774.6** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **257643405.0** | **330065757.7** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **39025305.0** | **53809957.7** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **39025305.0** | 53809957.7 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 39025305.0 | 53809957.7 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3398487.0 | 0.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 35626818.0 | 53809957.7 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **218618100.0** | **276255800.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 0.0 | 276255800.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.0 | 276255800.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2000000.0 | 0.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2000000.0 | 0.0 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 216618100.0 | 0.0 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 216618100.0 | 0.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **234877149.9** | **285977665.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **234877149.9** | **285977665.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 234877149.9 | 282430610.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 166470743.0 | 182861687.0 |
| 210101 | Үндсэн цалин | 166470743.0 | 182861687.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20808844.0 | 23067713.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14150013.0 | 15686045.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1664709.0 | 1845417.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1331767.0 | 1476334.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 332941.0 | 369083.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3329414.0 | 3690834.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14580000.0 | 16508800.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2652000.0 | 3434103.0 |
| 210302 | Түлш, халаалт | 10688000.0 | 11980297.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1240000.0 | 1094400.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13439000.0 | 19405245.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 2625950.0 | 4920130.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7578050.0 | 8930000.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1153310.0 | 1774930.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.0 | 8000.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.0 | 2160985.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2081690.0 | 1611200.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.0 | 825000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.0 | 825000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500000.0 | 12355990.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.0 | 500000.0 |
| 210604 | Урсгал засвар | 500000.0 | 11855990.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1200000.0 | 500000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1200000.0 | 500000.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5773000.0 | 3489710.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5450000.0 | 2869210.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150000.0 | 216000.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.0 | 256500.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 126000.0 | 126000.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22000.0 | 22000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 25000.0 | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12105562.9 | 23416465.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 395000.0 | 2500000.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11710562.9 | 20916465.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.0 | 3547055.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.0 | 920000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.0 | 920000.0 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.0 | 2627055.0 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 2627055.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **22766255.2** | **44088092.5** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **18766255.3** | **44088092.5** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **218618100.0** | **276255800.0** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **216618100.0** | **276255800.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 0.0 | 276255800.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.0 | 276255800.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2000000.0 | 0.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2000000.0 | 0.0 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 216618100.0 | 0.0 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 216618100.0 | 0.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **218618100.0** | **268754400.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **218618100.0** | **268754400.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **218618100.0** | **265207345.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 163141700.0 | 182268300.0 |
| 210101 | Үндсэн цалин | 117777800.0 | 126930288.9 |
| 210102 | Нэмэгдэл | 40252500.0 | 50134011.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5111400.0 | 5203999.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20818400.0 | 23582100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14262400.0 | 16708100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1639000.0 | 1718500.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1311200.0 | 1374800.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 327800.0 | 343700.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3278000.0 | 3437000.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15700000.0 | 16315400.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2652000.0 | 2943396.0 |
| 210302 | Түлш, халаалт | 11808000.0 | 11805297.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1240000.0 | 1566707.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11000000.0 | 21030000.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1721950.0 | 5800000.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7578050.0 | 8930000.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1153310.0 | 2017000.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.0 | 200000.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.0 | 1900000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 546690.0 | 2183000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.0 | 565000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.0 | 565000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500000.0 | 11680600.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.0 | 500000.0 |
| 210604 | Урсгал засвар | 500000.0 | 11180600.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1200000.0 | 500000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1200000.0 | 500000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5863000.0 | 4765945.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5540000.0 | 4145445.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150000.0 | 216000.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.0 | 256500.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 126000.0 | 126000.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22000.0 | 22000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 25000.0 | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 395000.0 | 4500000.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.0 | 2000000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 395000.0 | 2500000.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.0** | **3547055.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.0 | 920000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.0 | 920000.0 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.0 | 2627055.0 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 2627055.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.0** | **7501400.0** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **0.0** | **7501400.0** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.0** | **7501400.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0.0 | 7501400.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.0 | 7501400.0 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0.0** | **-7501400.0** |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 40,247,850.8 | 00.0 | 411,828,196.1 | 452,076,046.9 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **40,247,850.8** | **00.0** | **411,828,196.1** | 452,076,046.9 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.0 | 00.0 | -139,614,347.2 | -139,614,347.2 |
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **45,809,850.8** | **4,639,705.4** | **290,183,125.9** | 340,632,682.0 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **45,809,850.8** | **4,639,705.4** | **290,183,125.9** | 340,632,682.0 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **45,809,850.8** | **4,639,705.4** | **290,183,125.9** | 340,632,682.0 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.0 | 00.0 | 44,088,092.5 | 44,088,092.5 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **45,809,850.8** | **4,639,705.4** | **334,271,218.4** | 384,720,774.6 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 276255800.0 | 273628745.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 276255800.0 | 273628745.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 275335800.0 | 272708745.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 182268900.0 | 182268300.0 |
| 210101 | Үндсэн цалин | 135088400.0 | 126930288.9 |
| 210102 | Нэмэгдэл | 42069100.0 | 50134011.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5111400.0 | 5203999.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23582100.0 | 23582100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16708100.0 | 16708100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1718500.0 | 1718500.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1374800.0 | 1374800.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 343700.0 | 343700.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3437000.0 | 3437000.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16315400.0 | 16315400.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3005400.0 | 2943396.0 |
| 210302 | Түлш, халаалт | 11440000.0 | 11805297.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1870000.0 | 1566707.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21030000.0 | 21030000.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 5800000.0 | 5800000.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8930000.0 | 8930000.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2017000.0 | 2017000.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 200000.0 | 200000.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1900000.0 | 1900000.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2183000.0 | 2183000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 565000.0 | 565000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 565000.0 | 565000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19182000.0 | 19182000.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8001400.0 | 8001400.0 |
| 210604 | Урсгал засвар | 11180600.0 | 11180600.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 500000.0 | 500000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 500000.0 | 500000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7392400.0 | 4765945.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6771900.0 | 4145445.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216000.0 | 216000.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 256500.0 | 256500.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 126000.0 | 126000.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22000.0 | 22000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4500000.0 | 4500000.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2000000.0 | 2000000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2500000.0 | 2500000.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 920000.0 | 920000.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 920000.0 | 920000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920000.0 | 920000.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 276255800.0 | 273628745.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 276255800.0 | 273628745.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 276255800.0 | 273628745.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 12.0 | 12.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 2.0 | 2.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 2.0 | 2.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.0 | 8.0 |

# 3.АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын прокурорын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Сум дундын ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Б.Батбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч шатахуун зарцуулалтад тавих дотоод хяналт, замын хуудас, жолоочийн тооцоо бодолтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 01 дугаар сарын 27–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Аззаяа хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Прокурорын байгууллага нь прокурорын хяналтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, хууль ёсыг чанд сахиулах, хүний эрх, эрх чөлөөг аливаа хэлбэрээр зөрчүүлэхгүй байх, дээд шатны прокурорын хяналтыг сайжруулах гэсэн зорилтыг дэвшүүлэн хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих
- Шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох гэсэн үйл ажиллагааны чиглэлтэй ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын прокурорын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Улсын Ерөнхий прокурорын 2016 оны 04-р сарын 04-ны А/28 дугаар тушаалаар мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн боловч өнөөгийн нөхцөл байдал, байгууллагын онцлогт тохирсон бүртгэлийг тусгаж өгөх шаардлагатай.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба болон бусад хяналтын байгууллагууд 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Харин Улсын ерөнхий прокурорын газрын Дотоод хяналт шалгалтын хэлтсийн дотоод аудитын шалгалтаар тус газрын 2019, 2020 оны эхний 9 сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийжээ. Дотоод хяналт шалгалтаар 4 зөрчил илэрч, зөрчлийг арилган Улсын Ерөнхий Прокурорын дотоод хяналт, шалгалтын хэлтэст хүргүүлсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 257643.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2576.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 330065.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3300.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын прокурорын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44088.0 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| Авлага | 79.0 | 0.00 | -79.0 | -100% |
| Бараа материал | 8119.7 | 11891.9 | 3772.2 | 46.5% |
| Үндсэн хөрөнгө | 332433.9 | 372828.8 | 40394.8 | 12.2% |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 340632.6 | 384720.7 | 44088.0 | 12,9% |
| **Богино хугацаат өр төлбөр** | 0.00 | 0.00 | 0.00 | 0 |
| Цэвэр хөрөнгө, өмч | 340632.6 | 384720.7 | 44088.0 | 12.9% |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 340632.6 | 384720.7 | 44088.0 | 12.9% |

Авлага дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж 79.0 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд үүссэн ажиллагсадтай холбогдсон авлага барагдаж бууруулжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 11891.9 мянган төгрөг болж 3772.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ковидтой холбоотой Булган суманд бичиг хэргийн материал тасарсан тул 50 ш бичгийн цаас, принтерийн хор, 35 тн нүүрс нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 332433.9 мянган төгрөг, оны эцэст 372828.8 мянган төгрөгөөр болж 40394.8 мянган төгрөгөөр өссөн байна .

Үндсэн хөрөнгийн данс нь улсын ерөнхий прокурорын газрын хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтаар 27822.0 мянган төгрөгөөр барилгын дээврийн засвар, 25987.9 төгрөгийн тоног төхөөрөмж тавилга хэрэгслийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, өөрийн хөрөнгөөр 7501.4 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой өссөн байна.

УЕП-ын 2020 оны 06 сарын 18-ны өдрийн А/55 тоот тушаалаар 6801.6 төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 384720.7 мянган төгрөг болж тайлант онд 44088.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын прокурорын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 72422.3 мянган төгрөгөөр буюу 28.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 72422.3 мянган төгрөгийн орлогоос 41378.6 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 18183.1 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого, 12860.9 мянган төгрөгөөр цалин тэтгэмж болон урсгал зардал, тогтмол зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 51100.5 мянган төгрөгөөр буюу 21.7 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 12860.9 мянган төгрөг буюу 9.8 хувиар, тогтмол зардал, бусад урсгал шилжүүлэг, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал 382398.6 мянган төгрөг буюу 11.9 хувиар өссөн байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 426640.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 426640.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Монгол улсын Ерөнхий прокурорын 2019 оны 12 дугаар сарын 24-ны А/83 дугаар тушаалаар Булган сум дахь сум дундын прокурорын газрын 2020 оны төсвийг 236540.0 мянган төгрөгөөр, 2020 оны 12 дугаар сарын 18-ны А/108 дугаар тушаалаар 266603.9 мянган төгрөгөөр тодотгосон байна.

**Төсвийн гүйцэтгэл**:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 276255.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 276255.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 273628.7 мянган төгрөгийг зарцуулж 2627.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 273628.7 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь байцаан шийтгэх үйл ажиллагааны зардлыг 2627.0 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой томилолт, багаж хэрэгсэл, шатахуунтай холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт /мян.төг/

| код | хөтөлбөр, арга хэмжээ | мөнгөн дүн |
|---|---|---|
| 82315 | Байцаан шийтгэх үйл ажиллагааны зардал | 2627.0 |
| | ДҮН | 2627.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 159 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн батлагдсан 11 орон тооны хязгаараас илүү 1 орон тоогоор илүү хүн авч ажиллуулсан байна гэсэн 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийг хэрэгжүүлэхээр УЕПГ-руу 2020 оны 02 сарын 05-ны өдрийн 08 тоот танилцуулгаар орон тоо нэмүүлэх саналаа хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мян.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 70 |
| **Нийт дүн** | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 70 |

### 3.9. **АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 1914.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1914.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**<u>Залруулсан алдаа</u>**: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

**Аудитын зөвлөмж**: Аудитаар илэрсэн 1914.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. **БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. ***Шатахуун зарцуулалт:***

1.1. *<u>Илрүүлэлт</u>*: Жолоочийн тооцооны хуудаст авсан шатахуунаас явсан км-ыг илүү дутуу бичсэн. Бусдын машинд хийсэн шатахууны замын хуудас бичүүлээгүй, тооцоо бодоогүй, норм баримтлаагүйтэй холбоотой 1914.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

*<u>Эрсдэл:</u>* Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт алдагдах, тайлан баланс буруу илэрхийлэгдэх.

1.2. *<u>Өгсөн зөвлөмж</u>*: *Төсвийн тухай хуулийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; гэсэн заалтыг мөрдөн ажиллах, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх.*

1.3. *<u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: | Аудитын нэр: | ***Ховд аймгийн Булган сум дахь сум дундын прокурорын газрын* 2020 *оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: |
| **2021** | | | ХОА-2021/102/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Ховд аймгийн Булган сум дахь сум дундын прокурорын газар** | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2 | Жолоочийн тооцооны хуудаст авсан шатахуунаас явсан км-ыг илүү дутуу бичсэн. Бусдын машинд хийсэн шатахууны замын хуудас бичүүлээгүй, тооцоо бодоогүй, норм баримтлаагүй | 1914.5 | Зөвлөмж өгөх | Дарга, Нягтлан бодогч | Б.Батбаяр, Б.Мэсүүлэн |
| **ДҮН** | | 7217.6 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**